




УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийсэн нийцлийн аудитын тайлан



АЙМАГ, НИЙС Г.У.Л, СУМ,
ДҮҮРГИЙН ИТХ-ЫН НӨХӨН
СОНГУУЛЬ 2026

06.21



Нөхөн сонгуулийг 2026.06.21-ны өдөр зохион байгуулна.

Аймгийн ИТХ-ын 2 мандат	 Увс аймгийн 2 сумын хэсэгт
Сумын ИТХ-ын 4 мандат	 Увс аймгийн 4 сумын хэсэгт

Зардлын тайлангаа 1 намаас бусад нам, нэр дэвшигчид хуулийн хугацаанд гаргаж ирүүлсэн бөгөөд сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг хэтрүүлээгүй байна.

Тайлан бэлтгэсэн:	Агуулга	3
Дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь	Товчилсон үгийн тайлал	4
Аудитын менежер М.Бат-Амгалан	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	5
Ахлах аудитор Б.Авирмэд	Ерөнхий мэдээлэл	6
Аудитор Р.Аюуш	Бүлэг 1. Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчид аймаг нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийг мөрдөж ажилласан байна.	7
А.Нанжидмаа	1.1. Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцсон 3 нам, 15 нэр дэвшигч сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг бүртгүүлсэн байна.	7
Л.Шагдарсүрэн	1.2. Сонгуулийн зардлын тайланг 1 нам хуулийн хугацаанд гаргаж ирүүлээгүй байна.	7
2026 оны 09 дүгээр сар	1.3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэгт заасан хандивын хэмжээг хэтрүүлээгүй байна.	7
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7045-3317 дугаарын утсаар харилцана уу.	1.4. Сонгуулийн зардлын данс байршуулсан банк сонгуулийн санал авах ажиллагаа дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор нам, эвсэл, нэр дэвшигчийн дансны гүйлгээний мэдээллийг ирүүлсэн байна.	8
Хаяг: Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Улаангом сум 3 дугаар баг, аймгийн Засаг даргын тамгын газрын байр 304 тоот	Бүлэг 2. Сонгуулийн зардлын дансанд төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг хуульд заасан зориулалтын дагуу зарцуулсан байна.	9
	2.1. Нэг нэр дэвшигч хуульд заасан шаардлагыг хангаагүй хандивыг буцаан шилжүүлсэн байна.	9
	2.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэгт заасан хандив өгөхийг хориглосон этгээдээс хандив хүлээн аваагүй байна.	9
	2.3. Орон нутгийн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчид сонгуулийн зардлыг журмын дагуу зарцуулж, тайлагнасан байна.	9
	Бүлэг 3. Нам, нэр дэвшигчид сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг хэтрүүлээгүй байна.	11
	3.1. Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчид сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг хэтрүүлээгүй байна.	11
	3.2. Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчид мөнгөн бус хандив аваагүй байна.	13
	Дүгнэлт	14
	Зөвлөмж	15

Товчилсон үгийн тайлал:

Д/д	Товчлол	Товчилсон үгийн тайлбар
1	ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
2	АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
3	ЗДТГ	Засаг даргын тамгын газар
4	НА	Нийцлийн аудит

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь заалт, Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хийлээ.

Аудитын зорилт

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчид Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулиар хориглосон хандив авсан эсэх.
- Сонгуулийн зардлын дансанд төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг хуульд заасан зориулалтын дагуу зарцуулсан эсэх.

Хамарсан хүрээ

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчдийн зардлын тайлан болон холбогдох баримт материалыг хамруулав.

Арга зүй

Аудитыг АДБОУС 100, 400, 4100, Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын журмыг баримтлан, Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовын 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/26 дугаар тушаалаар баталсан “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”-ыг үндэслэн нам, эвслээс оруулсан хөрөнгө, иргэн, хуулийн этгээдээс авсан хандив түүний зарцуулалтын тайланг шалгаж, аудит хийсэн хуулийн этгээд, нам, эвслээс лавлагаа, тодруулга авч, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж тайланг бэлтгэв.

Аудитын багийн бүрэлдэхүүн

Нийцлийн аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь хянан удирдаж, аудитын менежер М.Бат-Амгалан аудитын стандартыг хангуулж, үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Авирмэд, аудитор Р.Аюуш, А.Нанжидмаа, Л.Шагдарсүрэн нар хийж гүйцэтгэв.

Ерөнхий мэдээлэл

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд 3 нам оролцож, нийт 15 нэр дэвшигч нэр дэвшсэн байна. Үүнд:

/Хүснэгт 1/

Намын нэр	Нам	Нэр дэвшигчид
Монгол ардын нам	1	6
Ардчилсан нам	1	6
ХҮН нам	1	2
Бие даагч		1
Нийт	3	15

Эх сурвалж: /Аймгийн сонгуулийн хороо/

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны ээлжит сонгуульд оролцсон 2 нам сонгуулийн зардлын тайлангаа хуулийн хугацаанд ирүүлж, 1 нам нь зардлын тайлан гаргаж ирүүлээгүй байна.

Мөн 15 нэр дэвшигч нь сонгуулийн зардлын тайлангаа хуулийн хугацаанд гаргаж ирүүлсэн байна.

Бүлэг: 1

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчид аймаг нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийг мөрдөж ажилласан байна.

1.1. Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцсон 3 нам, 15 нэр дэвшигч сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг бүртгүүлсэн байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.3 дахь хэсэгт “Нам, эвсэл болон нэр дэвшигч нь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй” гэж заасны дагуу Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцсон 3 нам, 15 нэр дэвшигч сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг бүртгүүлсэн байна.

1.2. Сонгуулийн зардлын тайланг 1 нам хуулийн хугацаанд гаргаж ирүүлээгүй байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3 дахь хэсэгт “Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ” гэж заасны дагуу 2 нам, 15 нэр дэвшигч хуульд заасан хугацаанд зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан ирүүлсэн байна.

Харин ХҮН нам зардлын тайлангаа хуулийн хугацаанд гаргаж ирүүлээгүй нь Увс аймгийн “ХҮН” намын хороо нь орон нутагт сонгуулийн данс нээгээгүй харин төв нам нь данс нээсэнтэй холбоотой байна. Аймаг, суманд үйл ажиллагаа явуулж байгаа намуудын салбар буюу аймаг, сумын намын хороо нь орон нутгийн нөхөн сонгуульд хөрөнгө бүрдүүлж оролцох боломжтой боловч Улс төрийн намын тухай хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд “нам” тайлан гаргана гэж заасан байгаагаас үүдэн эрх зүйн тодорхой бус, сонгуулийн зардалд хяналт хийгдэхгүй байх эрсдэлтэй нөхцөл байдлыг үүсгэж байна.

1.3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэгт заасан хандивын хэмжээг нам эвсэл, нэр дэвшигчид хэтрүүлээгүй байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэгт “Мөнгөн хандив иргэний хувьд 2.0 сая төгрөг хүртэл, хуулийн этгээдийн хувьд 10.0 сая төгрөг хүртэл байна” гэж заажээ.

Орон нутгийн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчдэд 2.0 сая төгрөгөөс дээш хэмжээний хандив өгсөн иргэн, 10.0 сая төгрөгөөс дээш хэмжээний хандив өгсөн хуулийн этгээд байхгүй байна.

1.4 Сонгуулийн зардлын данс байршуулсан банк сонгуулийн санал авах ажиллагаа дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор нам, эвсэл, нэр дэвшигчийн дансны гүйлгээний мэдээллийг ирүүлсэн байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5 дахь хэсэгт “Сонгуулийн зардлын данс байршуулсан банкны захирал, эсхүл салбарын эрхлэгч уг дансны бүх гүйлгээний хуулгыг гаргаж, санал авах өдрөөс хойш 30 хоногийн дотор төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ” гэж заасны дагуу нам, нэр дэвшигчдийн нээлгэсэн дансны хуулгыг Төрийн банк хуулийн хугацаанд гаргаж ирүүлсэн.

Бүлэг: 2

Сонгуулийн зардлын дансанд төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг хуульд заасан зориулалтын дагуу зарцуулсан байна.

2.1. Нэг нэр дэвшигч хуульд заасан шаардлагыг хангаагүй хандивыг буцаан шилжүүлсэн байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.4 дэх хэсэгт “Хандив өгч байгаа иргэн, хуулийн этгээд нь нэр, иргэний бүртгэлийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээллээ банкны гүйлгээний баримтад тусгах бөгөөд энэ шаардлагыг хангаагүй хандивыг хандив хүлээн авагч буцаан шилжүүлнэ” гэж заасны дагуу 1 нэр дэвшигч 7,900.0 мянган төгрөгийн хандивыг буцаан шилжүүлсэн байна.

Орон нутгийн нөхөн сонгуульд оролцсон нэр дэвшигчийн хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивыг буцаасныг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 1

мян.төг

№	Хандивлагч иргэн хуулийн этгээдийн нэр	Нийт хандивын хэмжээ	Шилжүүлгийн мэдээлэл			Буцаасан улсын орлого болгосон тухай тайлбар
			Буцаасан	Улсын орлого болгосон	Огноо	
1	Б.Найдалаа	1,000.0	1,000.0		2026.06.11	Нэр зөрүү
2	Т.Доржханд	2,000.0	2,000.0		2026.06.12	Орлогын эх үүсвэр дутуу
3	Б.Отгонтөгс	100.0	100.0		2026.06.12	Орлогын эх үүсвэр дутуу
4	С.Отгонбат	500.0	500.0		2026.06.12	Орлогын эх үүсвэр дутуу
5	Г.Майцэцэг	100.0	100.0		2026.06.12	Орлогын эх үүсвэр дутуу
6	Ц.Алтансор	500.0	500.0		2026.06.13	Регистр дутуу
7	Б.Ану	1,000.0	1,000.0		2026.06.13	Орлогын эх үүсвэр дутуу
8	Б.Нямзаяа	500.0	500.0		2026.06.14	Орлогын эх үүсвэр дутуу
9	Р.Эрдэнэбилэг	200.0	200.0		2026.06.17	Орлогын эх үүсвэр дутуу
10	Л.Одсүрэн	1,000.0	1,000.0		2026.06.17	Орлогын эх үүсвэр дутуу
11	Н.Солонго	1,000.0	1,000.0		2026.06.17	Орлогын эх үүсвэр дутуу
Нийт		7,900.0	7,900.0			

/Эх сурвалж: Дансны хуулга/

2.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэгт заасан хандив өгөхийг хориглосон этгээдээс хандив хүлээн аваагүй байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэгт “Дараах этгээд хандив өгөхийг хориглоно” гэж заажээ. Үүнд:

- 55.1.1. Гадаад улс буюу гадаадын болон олон улсын байгууллага, гадаадын хөрөнгө оруулалттай байгууллага, төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага;
- 55.1.2. Гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн;
- 55.1.3. 18 нас хүрээгүй хүн;

- 55.1.4. Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд;
- 55.1.5. Шүүхийн шийдвэрээр тогтоогдсон албан татварын өр төлбөртэй, дампуурсан хуулийн этгээд;
- 55.1.6. Үйлдвэрчний эвлэл, шашны байгууллага;
- 55.1.7. Байгуулагдаад нэг жил болоогүй байгаа хуулийн этгээд гэж заажээ.

Орон нутгийн ИТХ-ын 2026 оны нөхөн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчид дээрх хуулийн заалтуудыг зөрчөөгүй байна.

2.3. Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчид сонгуулийн зардлыг журмын дагуу зарцуулж, тайлагнасан байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсэгт "Сонгуулийн сурталчилгааг дараах арга, хэлбэрээр явуулна",

- 38.2.1.сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах;
- 38.2.2.нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар байрлуулах;
- 38.2.3.хуульд өөрөөр заагаагүй бол намын далбааг гудамж талбайд байрлуулах, таних тэмдэг, уриа ашиглах;
- 38.2.4.сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх;
- 38.2.5.ухуулах байр ажиллуулах;
- 38.2.6.радио, телевизийн сурталчилгааны нэвтрүүлэг ашиглах;
- 38.2.7.цахим орчин ашиглах;
- 38.2.8.өдөр тутмын болон бусад сонин, сэтгүүлд сонгуулийн сурталчилгааны материал нийтлүүлэх.

гэж заасны дагуу нөхөн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчид сонгуулийн үйл ажиллагааны зардлыг хуульд заасан зориулалтаар нь зарцуулж, тайлагнасан байна. Үүнд:

Бүлэг: 3 Нам, нэр дэвшигчид сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг хэтрүүлээгүй байна.

3.1. Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчид сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг хэтрүүлээгүй байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.5 дахь хэсэгт “Сонгуулийн зардлын дансанд хуримтлагдах хөрөнгийн хэмжээнд тусгайлан хязгаар тогтоохгүй боловч тухайн сонгуулийн сурталчилгааны хугацаанд сонгуулийн зардлын данснаас зарцуулах зардлын хэмжээ нь энэ хуульд заасны дагуу тогтоосон сонгуулийн зардлын дээд хэмжээнээс хэтрэхгүй” гэж заасны дагуу нам, нэр дэвшигчид зардлын дээд хэмжээг хэтрүүлээгүй байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэгт “Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ” гэж заажээ.

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчдэд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэний нэрсийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 2				мян.төг	
д/д	Тойргийн дугаар	Нэр дэвшүүлсэн нам, эвслийн нэр	Нэр дэвшигчийн овог, нэр	Иргэнээс өгсөн мөнгөн хандив	
				Иргэний нэр	Дүн /мянган төгрөг/
1	Аймгийн 16-р тойрог	ХҮН	Д.Батсайхан	Т.Доржханд	2,000.0
2				Д.Гантулга	1,000.0
3				Б.Ану	1,000.0
4				Б.Найдалаа	1,000.0
5				Л.Одсүрэн	1,000.0
6				О.Цэцэгбал	1,000.0
7				н.Болор-Эрдэнэ	1,000.0
Нийт					8,000.0

Эх сурвалж: /Дансны хуулга/

Орон нутгийн нөхөн сонгуульд оролцсон 1 нэр дэвшигчид 7 иргэнээс нийт 8,000.0 мянган төгрөгийн 1 ба 2 сая төгрөгийн хандив өгсөн байна.

3.2 Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчид мөнгөн бус хандив аваагүй байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1 дэх хэсэгт “Мөнгөн бус хандивт дараах зүйл хамаарна”

54.1.1. Үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийг ашиглуулах, эзэмшүүлэх;

54.1.2. Үйлчилгээ үзүүлэх.

54.2. Мөнгөн бус хандивыг сонгуулийн сурталчилгаа эхэлсэн өдрөөс дуусах хүртэл хугацаанд зөвхөн нэр дэвшигчид өгнө.

54.3. Мөнгөн бус хандив өгч байгаа тохиолдолд хандивлагч нь нэр дэвшигч, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй хандивын гэрээг бичгээр байгуулж гэрээнд заасан зориулалтын дагуу зарцуулна.

54.4. Мөнгөн бус хандивын үнэлгээг зах зээлийн дундаж ханшийг үндэслэн хандивын гэрээгээр тогтоох бөгөөд уг үнэлгээ нь иргэн болон хуулийн этгээдээс өгөх хандивын дээд хэмжээнээс хэтрэхгүй байна гэж заажээ.

Орон нутгийн нөхөн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчид мөнгөн бус хандив аваагүй байна.

Дүгнэлт

Нийцлийн аудитын явцад олж цуглуулсан нотлох зүйлс, баримт материал, судалгаанд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Орон нутгийн нөхөн сонгуульд оролцсон 3 нам, 15 нэр дэвшигч сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг бүртгүүлсэн байна.
2. Орон нутаг дахь зарим намын салбар нь хуулийн этгээд биш байгаагаас сонгуулийн зардлын тайлан ирүүлээгүй намын салбар хороонд арга хэмжээ авах хууль эрх зүйн орчин тодорхой бус, сонгуулийн зардалд хяналт хийгдэхгүй байх эрсдэлтэй нөхцөл байдлыг үүсгэж байна.
3. Нэг нэр дэвшигч нь нэр, регистрийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээллээ тусгаагүй 11 иргэний нийт 7,900.0 мянган төгрөгийн хандивыг буцаан шилжүүлсэн байна.
4. Орон нутгийн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчид хуулийн дагуу тогтоосон зардлын дээд хэмжээг хэтрүүлээгүй байна.
5. Орон нутгийн нөхөн сонгуульд оролцсон 1 нэр дэвшигчид 7 иргэн 8,000.0 мянган төгрөгийн нэг сая ба хоёр сая төгрөгийн хандив өгсөн байна.

ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР
БЭЛТГЭСЭН:
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

АУДИТЫН ТАЙЛАНГ:



/М.БАТ-АМГАЛАН/

/Б.АВИРМЭД/

/Р.АЮУШ/

/А.НАНЖИДМАА/

/Л.ШАГДАРСҮРЭН/